

ороход нөлөө үзүүлжээ. Түүнчлэн энэ хугацаанд хятадын удирдагчдаас өнөө хэрэгжүүлж байгаа гадаад, дотоод бодлогын чиг шугамыг үндсэнд нь тодорхойлсон ХКН-ын 11 дэх удаагийн Ш бүгд хурал, ХКН-ын XII их хурал, хуралдав. 80-аад оны эхээр үндэстний талаар явуулж ирсэн их хан үндэстний дээрэнгүй уусгах бодлого түүнд шүүмжлэлтэй хандах бодлогоор солигдож эхэллээ. Үндэстний районуудын нийгэм-эдийн засаг, соёлын салбарт зарим нэг өөрчлөлт ажиглагдах болов. Энэ бүхнийг зохиогчид бодит баримт материал дээр тулгуурлан үнэлэлт, дүгнэлттэй бичжээ.

ШУА-ийн Хэвлэх үйлдвэрээс эрхлэн хэвлэж саяхнаас худалдаанд гарч буй энэ бүтээл нь зөвхөн түүх, дорнодахин, хятад судлалын мэргэжлийн хүмүүст төдийгүй их дээд сургуулийн багш, окутан сурагчдад түүнчлэн уг асуудлыг сонирхогч бусад уншигчдад гарын авлага болохуйц ном болсон байна.

Л. Лхамдулам

**ШИГЭО ОЗАВА «КИНДАЙНО
МОНГОРҮ» (Орчин үеийн
Монгол) номын тухай Токио. 1978.**

Монголын судлалд багагүй хувь нэмэр оруулсан Токиогийн Гадаад хэлний дээд сургуулийн профессор, монголч эрдэмтэн Шигэо Озава манай оронд олон удаа ирж байсан ба Монголч эрдэмтний 5 их хуралд оролцсон хүн юм. Тэрээр монгол орноор явж байхдаа үзэж харсан, сонсож мэдсэн зүйлдээ болон өөрийн судалгааны ажилд тулгуурдан «Орчин үеийн Монгол» номоо бичжээ.

Энэ ном нь «Монголын үүрийн гэгээ», «Үлгэр домгийн Монгол орон», «Миний Монгол» гэсэн гурван бүлгээс бүрджээ.

Зохиогч энэ бүтээлдээ монголын ард түмний түүх, нийгэм улс төр, соёл шинжлэх ухааны ололт амжилт, монголчуудын зан заншил, монгол орны байгалийн гоо сайхан, малчдын амьдрал, монгол хэлний тухай голлон тусгаж, Япон-Монгол, Зөвлөлт-Монгол Хятад-Монголын харилцааны талаар өөрийн үзэл бодлоо цухас дурджээ.

Зохиогч. . Шинэ монголын нүүр царай нь шинэ хуучин хоёр ертөнцөд багтана. Нэг дэх нь Улаанбаатар хот бэлхнээ гэрчлэх нийслэлийн дүр төрх, хоёр дахь нь хангай говь хээр талын ертөнц юм. Энэ хоёроос «Орчин үеийн Монгол»-ыг эрж болно (50-р тал) гээд Улаанбаатар хотын түүх, хотын хөгжил цэцэглэлт, ололт амжилтыг дэлгэрэнгүй өгүүлжээ. . Хувьсгалаас өмнө эсгий гэр, сүм дуган, цөөн тооны модон байшин замбараагүй зэрэгцсэн хот байсан гэгдэх Хүрээ нь (55-р тал) шинэчлэгдэн өөрчлөгдөж орчин үеийн шинэ хот болсныг «нарны гэрэлд нүд гялбам цайран гэрэлтэх энэхүү хотыг «Гэрэлт хот» хэмээн нэрлэвэл илүү тохиромжтой (51-р тал) гэжээ.

Цааш нь: . Монгол орон малчдын орон байсныг эргэн тойрны эдгээр юмс үндсэндээ мартагдуулах мэт. Эртнээс нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн малчин ардууд энэ сайхан хотыг барьж байгуулсан юм. Үүнд зөвлөлтийн тусламж ч бас бий (55-р тал) гээд шинэч-

лэгдэн сэргэн мандсан орчин үеийн хот болоход монголын ард түмний хүчин чармайлт, түүний материаллаг бааз орсныг өндрөөр үнэлвэл зохино (55-р тал) гэж цохон тэмдэглэжээ.

Зохиогч манай оронд байх хугацаандаа говь, хээр, хөдөө орон нутгаар зочилж малчид, хөдөлмөрчид янз бүрийн давхаргын хүмүүстэй уулзан ярилцаж явахдаа, биеэр мэдэрсэн, монгол хүний эх орноо хайрлах хайр, эх орон түмнээ гэсэн оргилуун сайхан сэтгэлийг япон уншигчдад танилцуулахыг эрмэлзжээ. .. Монголд хамгийн сайхан газар хаана байдаг вэ гэж тэднээс асуухад төрж өссөн газар нутаг хамгийн сайхан хэмээн бүгд шийдвэртэй хариулна. Тэд өөртөө амьдрал хайрласан эх болох Монголын уудам нутгийг ийнхүү энхрийлэн хайрлах юм. Төрсөн эх нутгаа, эх орноо чин сэтгэлээсээ хайрлах хүн азтай юм даа (36-р тал) гэжээ.

БНМАУ-ын социалист бүтээн байгуулалт, аж үйлдвэр, хөдөө аж ахуйд олсон ололт амжилт, түүнд ЗХУ-аас үзүүлж буй тусламж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгааг зохиогч тодорхой баримт жишээгээр гаргажээ (71-86-р тал).

Проф. Озава зохиолдоо «Монголын урлаг, утга зохиол болон түүхийн зарим асуудлыг хөндөж тэдгээрийн талаар монголоор аялсан жирийн нэгэн тойрон аялагчийн хэмжээнд биш монголыг судалдаг монголч эрдэмтний хэмжээнд нэлээд бодитой бөгөөд тодорхой ойлголт өгөхийг оролдсон нь харагдаж байна (86—99-р тал).

Зохиолын II бүлэгт ардын аман зохиолын төрөл зүйл болох ертөнцийн гурав, дөрөв, оньсого, зүйр үг зэргийг япон хэлнийхтэй харьцуулан үзүүлснээс гадна «Монголын нууц товчоо»-ны тухай сонирхолтой судалгаа хийсэн байна. Тэрчлэн монголчуудын гэрлэх, хуримлах ёс заншил, ёслолын тухай бичихдээ хувьсгалын өмнөх байдлыг одоогийнхтой харьцуулжээ. Хувьсгалаас өмнө залуу хосууд сэтгэлтэй хүнтэйгээ ханилан сууж чадалгүй, лам нарын мэргэ төлөгт төөрөгдөн жаргалаа эдэлж чаддаггүй байсан бол шинэ нийгэм байгуулагдснаар энэ бүхэн өөрчлөгдснийг “Монголын социалист шинэ нийгэм нь өнөөгийн залуучуудын амьдрах сайн сайхан нийгэм болжээ. Залуу хосууд өөрсдийн сайн дурын үндсэн дээр хуримлаж чаддаг боллоо. Ер нь монголын шинэ нийгэм нь бүх талын өөрчлөлт хийсэн юм» (125-р тал) гэж дурджээ.

Зохиолын III бүлэгт хүмүүстэй уулзсан тухай сэтгэгдэл, дурсамж мөн өөрийн эрдэм шинжилгээний ажлын зорилго, үр дүнгээс өгүүлсэн байна. Тэрээр, шинжлэх ухаан нь хязгааргүй зүйл юм. Миний бие монгол хэлийг 20 гаруй жил судалж байгаа боловч «мэдэхгүй» зүйл барагдахгүй их байна. Монгол хэл гэдэг чинь зөвхөн хэлээр хязгаарлагдахгүй. Монгол хэлний цаана түүх, соёл, зан заншил, урлаг утга зохиол гээд олон зүйл бий. Иймд «судалгааны судалгаа» үргэлжилсээр байх болно (193—194-р тал) гээд монгол хүн энх тайвныг эрхэмлэн хайрладаг ариун цагаан сэтгэлт хүмүүс билээ. Тэгээд ч тэд «хиргүй цагаан сэтгэл», «цагаан зам», «арван цагаан буян» гэж цагаан өнгийг «баяр баясгалангийн өнгө» хэмээн биширдэг байна. Эртний түүх бичгийн зохиолоос үзвэл “Хөх Монгол улс», «Хөх орд», «Хөх түүх» гэх зэргээр хөх өнгийг улс төрийн болон төр засгийн зүйлд эрхэмлэн дээдэлдэг нь тэд үргэлж хөх тэнгэртэй, энх тайван байхыг эрхэмлэдэгтэй холбоотой юм (200-р тал) гэжээ.

Зохиогчийн хэлснээр уг ном нь монгол хэлийг сурч судалж ирсний хувьд өнөөгийн япончуудад ялангуяа залуу үеийнхэнд монгол орныг бага ч гэсэн таниулах зорилгоор бичсэн бүтээл төдийгүй ха-

рин Япон дахь монгол судлалд, ялангуяа монголын нийгэм эдийн засгийн хөгжилт, соёл урлагийн талаар зохих хувь нэмэр оруулахуйц бүтээл болжээ. Гэвч уг номонд Монгол-зөвлөлтийн интернационалч шинэ маягийн харилцааны онцлог зэрэг зарим асуудалд хааш яаш хандсанаас уншигчдад ташаа зөрүү сэтгэгдэл төрүүлэх үг үсэг цухалзаж буй нь бодит үнэнд үл нийцэх талтайг дурдах хэрэгтэй юм.

Ч. Куланда